2015 оны эхний 5 сард орон нутгийн төсвөөс төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 53.1 хувийг буюу 292.2 тэрбум төгрөгийн зардлыг санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 46.9 хувийг буюу 258.5 тэрбум төгрөгийг төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.

Зураг 21. Нийслэлийн төсвийн зарлага, сая төгрөг



Төсвийн нийт зарлагын 27.4 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 3.0 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 9.7 хувийг татаас болон урсгал шилжүүлэг, 12.3 хувийг нийгмийн халамжийн үйлчилгээ, 15.9 хувийг хөрөнгийн зардал, 31.7 хувийг бараа ажил үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Хүснэгт 21. Нийслэлийн төсвийн зарлага, сая төгрөг

	Орлогын дүн	Зарлага				Орлого, зарлагын зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь	зөрүү	
Багануур	4872.5	6346.5	5101.2	80.4	132.7	-228.7
Багахангай	1258.0	2376.7	1575.9	66.3	-800.8	-317.9
Баянгол	27067.4	30443	23837.8	78.3	-6605.2	3229.6
Баянзүрх	31939.6	34680.1	28035.2	80.8	-6644.9	3904.4
Налайх	5156.5	7158.5	6427.1	89.8	-731.4	-1270.6
Сонгинохайрхан	28036.8	30776.3	26281.2	85.4	-4495.1	1755.6
Сүхбаатар	27794.0	29170.5	20380.0	69.9	-8790.5	7414.0
Хан-Уул	21594.4	21591.5	16800.2	77.8	-4791.3	4794.2
Чингэлтэй	24645.8	26167.8	17633.3	67.4	-8534.5	7012.5
Нийслэлийн шууд	153262.7	361984.7	146089.3	40.4	-215895.4	7173.4
Нийт дүн	325627.7	550695.6	292161.2	53.1	-258534.4	33466.5

Нийслэлийн төсөв болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсвөөс санхүүждэг байгууллагууд сарын эхэнд 1324.1 сая төгрөгийн өглөгтэй байснаас тайлант хугацаанд шинээр 728.5 сая төгрөгийн өглөг үүсч, тухайн сард 375.3 сая төгрөгийн өглөгийг төлж барагдуулан, сарын эцэст 1321.9 сая төгрөгийн өглөгтэй үлдсэн байна.

Хүснэгт 22. Өглөгтэй дүүргүүд, сая төгрөг

	5-р сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн өглөг	Тухайн сард төлөгдсөн	5-р сарын эцсийн үлдэгдэл	Төсөвт байгууллагууд сарын эхэнд 526.4 сая төгрөгийн авлагатай байснаас тайлант хугацаанд шинээр 12.7 сая төгрөгийн авлага үүсч, 4.8 сая төгрөгийн авлагыг барагдуулан сарын эцэст 534.3 сая төгрөгийн авлагатай үлджээ.
Багануур	77.2	23.1	13.9	86.4	
Багахангай	2.7	2.8	0.9	4.6	
Баянгол	357.9	338.7	49.5	647.1	
Баянзүрх	117.5	73.5	27.4	163.6	
Налайх	192.9	81.6	39.6	234.9	
Сонгинохайрхан	120.8	33.6	90.7	63.7	
Сүхбаатар	139.8	112.5	75.3	177.0	
Чингэлтэй	44.2	1.6	33.9	11.9	
Хан-Уул	121.5	43.9	42.5	122.9	
Нийслэлийн шууд	149.6	17.2	1.6	165.2	
Нийт	1324.1	728.5	375.3	1321.9	

Хүснэгт 23. Авлагатай дүүргүүд, сая.төгрөг

	5-р сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн авлага	Тухайн сард барагдуулсан	5-р сарын эцсийн үлдэгдэл
Багануур	3.6	0.0	0.0	3.6
Багахангай	2.1	0.0	0.0	2.1
Баянгол	42.6	2.5	2.2	42.9
Баянзүрх	2.1	0.0	0.0	2.1
Сонгинохайрхан	4.7	2.8	0.0	7.5
Сүхбаатар	25.0	6.9	0.0	31.9
Чингэлтэй	2.3	0.5	0.2	2.6
Нийслэлийн шууд	444.0	0.0	2.4	441.6
Нийт	526.4	12.7	4.8	534.3




## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2015 оны эхний 5 сард нийслэлийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 22.7 мянган байгууллагын 496.0 мянган иргэд хамрагдаж нийгмийн даатгалын шимтгэл төлжээ.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч нийт иргэдийн 322.6 мянга буюу 65.0 хувь нь аж ахуйн нэгж байгууллагын, 95.4 мянга буюу 19.2 хувь нь төсөвт байгууллагын, 78.0 мянга буюу 15.7 хувь нь сайн дурын даатгуулагчид байна. Даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 3.6 хувиар буюу 17.4 мянган хүнээр нэмэгджээ.

Нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагууд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 94.4 хувиар биелүүлж, нийгмийн даатгалын санд нийт 281.3 тэрбум төгрөг хуримтлуулсан байна.

Зураг 22. Даатгалын сангийн орлого, сая төгрөг      Зураг 23. Даатгалын сангийн зарлага



Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 63.7 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 18.8 хувь нь эрүүл мэндийн даатгалын санд, 7.2 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 8.6 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 1.7 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

Нийслэлийн нийгмийн даатгалын сангаас энэ оны эхний 5 сард даатгуулагч, иргэдэд 348.4 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сургалтын болон эмчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгожээ. Нийт зардлын 71.7 хувийг тэтгэврийн, 13.7 хувийг эрүүл мэндийн, 6.6 хувийг ҮОМШӨ-ний, 6.1 хувийг тэтгэмжийн, 1.9 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо 5 дугаар сард 144.5 мянга, олгосон тэтгэврийн хэмжээ өссөн дүнгээр 214.6 тэрбум төгрөгт хүрчээ. Олгосон нийт тэтгэврийн 74.2 хувийг өндөр насны, 10.3 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.5 хувийг тэжээгчээ алдсаны, 12.0 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.



### ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Хөдөлмөрийн яамны захиргааны статистик мэдээгээр дүүргийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо нийслэл хотод 2015 оны 5 дугаар сарын эцэст 12250 болж, өмнөх оны мөн үеэс 9.2 хувь буюу 1242 хүнээр буурчээ. Нийт ажилгүйчүүдийн 6350 буюу 51.8 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зураг 24. Дүүргийн ажилгүйчүүд, УБ хотын дүнд эзлэх хувь



Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 18.8 хувь буюу 2301 нь 15-24 насны, 38.3 хувь буюу 4689 нь 25-34 насны, 22.8 хувь буюу 2798 нь 35-44 насны, 20.1 хувь буюу 2462 нь 45-аас дээш насны хүмүүс байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 16.3 хувь буюу 2002 нь Чингэлтэй, 15.8 хувь буюу 1940 нь Баянзүрх, 14.7 хувь буюу 1800 нь Хан-Уул, 14.3 хувь буюу 1751 нь Сүхбаатар, 13.6 хувь буюу 1661 нь Баянгол, 12.1 хувь буюу 1478 нь Сонгинохайрхан, 9.1 хувь буюу 1110 нь Налайх, 3.4 хувь буюу 422 нь Багануур, 0.7 хувь буюу 86 нь Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

2015 оны 5-р сард ажилгүй 4323 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй байсан 806 иргэн ажилд зуучлагдан орж, 4943 иргэн бүртгэлээс хасагджээ.

Хүснэгт 24. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр /6-р сарын 1-ний байдлаар/

	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2013 он	2014 он	2015 он	2013 он	2014 он	2015 он
Нийт ажилгүйчүүд	12467	13492	12250	100	100	100
Үүнээс: дээд боловсролтой	4108	5784	4294	32.9	42.9	35.1
Тусгай дунд боловсролтой	1116	1010	909	9.0	7.5	7.4
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	810	771	641	6.5	5.7	5.2
Ерөнхий боловсролтой	6373	5868	6337	51.1	43.5	51.7
Мэргэжилгүй	60	59	69	0.5	0.4	0.6

2015 оны эхний 5 сард 19314 хүн дүүргийн хөдөлмөрийн хэлтэст ажилд орохоор шинээр бүртгүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 26.9 хувь буюу 4099 хүнээр өсчээ.

2015 оны эхний 5 сард 2801 хүн хөдөлмөрийн хэлтсээр зуучлуулан ажилд орсны 2.8 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт, 5.4 хувь нь төсөвт байгууллагад, 91.8 хувь нь компани, нөхөрлөл, хоршоо болон бусад газарт ажилд оржээ.





### ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2015 оны эхний 5 сард 17196 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 276 хүүхдээр олон байна. Нийт төрсөн хүүхдийн 13.0 хувь буюу 2231 нь бусад аймгийн харьяат эхчүүдээс төрсөн байна.

Хүснэгт 25. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл, эхний 5 сард


	2013 он	2014 он	2015 он	$\frac{2015}{2014} \%$
Амаржсан эхийн тоо	16243	16765	17052	101.7
Амьд төрсөн хүүхэд	16357	16920	17196	101.6
Эхийн эндэгдэл	9	6	5	83.3
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	227	259	260	100.4
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	13.88	15.31	15.12	98.8

Нялхсын эндэгдлийн 28.9 хувь буюу 50 нь Сонгинохайрхан, 21.4 хувь буюу 37 нь Баянзүрх, 12.1 хувь буюу 21 нь Сүхбаатар, 12.1 хувь буюу 21 нь Чингэлтэй, 10.4 хувь буюу 18 нь Баянгол, 10.4 хувь буюу 18 нь Хан-Уул, 3.5 хувь буюу 6 нь Налайх, 1.2 хувь буюу 2 нь Багануур дүүрэгт тус тус гарсан байна.

Нялхсын эндэгдлийн 33.5 хувь буюу 87 нь бусад аймгийн харьяат байна. Өмнөх оны мөн үеэс нялхсын эндэгдэл 0.19 промилээр буурчээ.

Нийслэлд 2015 оны эхний 5 сард 11737 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 63.1 хувь буюу 4543 хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 33.24 продицилээр тус тус өсчээ.

Зураг 25. Халдварт өвчнөөр өвчлөгсөд, сараар



Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 29.0 хувийг улаан бурхан, 15.6 хувийг тэмбүү, 15.0 хувийг салхинцэцэг, 10.4 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 7.2 хувийг заг хүйтэн, 6.3 хувийг трихомониаз, 4.2 хувийг гар хөл амны өвчин, 2.9 хувийг цусан суулга, 1.9 хувийг вируст гепатит, 1.6 хувийг улаан эсэргэнэ, 0.8 хувийг хоолны хордлого өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.

Хүснэгт 26. Нийслэлд гарсан халдварт өвчин, эхний 5 сард

	хэмжих нэгж	2014 он	2015 он	өсөлт, бууралт	
				тоо/пункт	Хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн бүх хүн, үүнээс	бодит тоо	7194	11737	4543	1.6 дах
	10000 хүнд	57.69	90.93	33.24	
Вируст гепатит	бодит тоо	261	228	- 33	- 12.6
	10000 хүнд	2.09	1.77	- 0.32	
Менингит	бодит тоо	4	2	- 2	- 50.0
	10000 хүнд	0.03	0.02	- 0.01	
Цусан суулга	бодит тоо	369	338	- 31	- 8.4
	10000 хүнд	2.96	2.62	- 0.34	
Салхин цэцэг	бодит тоо	1246	1757	511	41.0
	10000 хүнд	9.99	13.61	3.62	
Гахай хавдар	бодит тоо	109	25	- 84	- 4.4 дах
	10000 хүнд	0.87	0.19	- 0.68	
Сальмонеллэз	бодит тоо	12	21	9	1.8 дах
	10000 хүнд	0.10	0.16	0.06	
Улаан эсэргэнэ	бодит тоо	95	187	92	2.0 дах
	10000 хүнд	0.76	1.45	0.69	
Улаан бурхан	бодит тоо	-	3402	3402	-
	10000 хүнд	-	26.36	26.36	
Хоолны хордлого	бодит тоо	64	93	29	1.5 дах
	10000 хүнд	0.51	0.72	0.21	
Ёлом	бодит тоо	27	39	12	1.4 дах
	10000 хүнд	0.22	0.30	0.08	
Бруцеллэз	бодит тоо	7	8	1	14.3
	10000 хүнд	0.06	0.06	0	
Нярайн халдвар	бодит тоо	2	3	1	1.5 дах
	10000 хүнд	0.02	0.02	0	
Гар хөл амны өвчин	бодит тоо	601	491	- 110	- 18.3
	10000 хүнд	4.82	3.80	- 1.02	
Тэмбүү	бодит тоо	1604	1835	231	14.4
	10000 хүнд	12.86	14.22	1.36	
Заг хүйтэн	бодит тоо	597	848	251	42.0
	10000 хүнд	4.79	6.57	1.78	
Трихомониаз	бодит тоо	707	744	37	5.2
	10000 хүнд	5.67	5.76	0.09	
Шинээр илэрсэн сүрьеэ	бодит тоо	1170	1223	53	4.5
	10000 хүнд	9.38	9.48	0.1	
ДОХ	бодит тоо	17	6	- 11	- 2.8 дах
	10000 хүнд	0.14	0.05	- 0.09	



### АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж температур 2015 оны 5-р сард дунджаар 9.0°C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 0.8°C-аар, олон жилийн дундажтай харьцуулбал 0.8°C-аар тус тус дулаан байлаа. Энэ сард үнэмлэхүй их температур 28.0°C, үнэмлэхүй бага температур -5.0°C, хур тунадасны нийлбэр 12.3 мм, салхины үнэмлэхүй их хурд 19 м/секунд хүрч, шороон болон цасан шуургатай 5 тохиолдлыг бүртгэжээ.


Хүснэгт 27. Агаарын бохирдолт, мг/м<sup>3</sup>

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хийсэн ажиглалтын тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдол /тоо/	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO <sub>2</sub>	0.020	227	0.063	38	0.013
Азотын давхар исэл	NO <sub>2</sub>	0.040	290	0.075	63	0.028
Тоосжилт	PM <sub>10</sub>	0.100	276	0.379	119	0.104
	PM <sub>2.5</sub>	0.050	169	0.098	18	0.032
Нүүрстөрөгчийн дутуу исэл	CO	10.000	700	13.225	1	0.489
Озон	O <sub>3</sub>	0.100	670	0.103	-	0.049


\*- Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар

Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2015 оны 5-р сард Улаанбаатар хотын 13-р хороолол орчимд 31 удаа, Баруун дөрвөн зам орчимд 28 удаа, 32-ын тойрог орчимд 3 удаа, 1-р хороолол орчимд 1 удаа, хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж Амгалан орчимд 17 удаа, Баруун дөрвөн зам орчимд 8 удаа, Толгойт орчимд 6 удаа, 13-р хороолол орчимд 4 удаа, Телевиз орчимд 3 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давжээ.


Зураг 26. Хүхэрлэг хийн агууламж, мг/м<sup>3</sup>



Зураг 27. Азотын давхар ислийн агууламж, мг/м<sup>3</sup>




Зураг 28. Тоосны /PM<sub>10</sub>/ агууламж, мг/м<sup>3</sup>



10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Нисэх болон Толгойт орчимд тус бүр 20 удаа, 32-ын тойрог орчимд 19 удаа, Телевиз орчимд 17 удаа, Амгалан орчимд 15 удаа, Хархорин орчимд 12 удаа, Баруун дөрвөн зам болон 13-р хороолол орчимд тус бүр 7 удаа, Мишээл экспо төв болон Ургах наран хороолол орчимд тус бүр 1 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Толгойт орчимд 9 удаа, Нисэх орчимд 5 удаа, 13-р хороолол орчимд 4 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.

Зураг 29. Нүүрстөрөгчийн дутуу исэл, мг/м<sup>3</sup>



Хүснэгт 28. Агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м<sup>3</sup>, 5-р сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл- Экспо төв	Баруун дөрвөн зам	1-р хороолол	13-р хороолол	32-ын тойрог	Офицеруу- дын ордон	Хархорин зах	Ургах наран хороолол	Нисэх	Толгойт	Телевиз	Амгалан
Хүхэрлэг хий SO <sub>2</sub>	Дундаж	-	0.014	-	0.011	0.009	-	0.008	-	0.009	0.013	0.014	0.027
	Хамгийн их	-	0.029	-	0.026	0.020	-	0.017	-	0.019	0.047	0.029	0.063
	ХХХ*-с давсан хувь	-	26	-	13	-	-	-	-	-	21	11	74
	Хэмжилтийн тоо	-	31	-	31	31	-	26	-	29	29	27	23
Азотын давхар Исэл NO <sub>2</sub>	Дундаж	-	0.059	0.022	0.056	0.030	0.020	-	0.018	0.011	0.014	0.024	0.023
	Хамгийн их	-	0.075	0.041	0.070	0.044	0.036	-	0.034	0.018	0.025	0.034	0.038
	ХХХ*-с давсан хувь	-	90	3	100	10	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	31	30	31	31	28	-	31	29	29	27	23
Нүүрс- төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	-	0.702	-	0.679	-	-	0.427	0.433	0.298	0.434	0.679	0.263
	Хамгийн их	-	1.100	-	1.350	-	-	1.514	13.225	0.636	1.421	2.260	0.530
	ХХХ*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	1	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	91	-	93	-	-	81	91	92	92	87	73
Тоос PM10	Дундаж	0.064	0.079	-	0.073	0.132	-	0.098	0.040	0.150	0.160	0.124	0.123
	Хамгийн их	0.159	0.156	-	0.165	0.301	-	0.302	0.106	0.379	0.326	0.216	0.199
	ХХХ*-с давсан хувь	4	23	-	23	61	-	44	5	69	69	65	65
	Хэмжилтийн тоо	27	31	-	31	31	-	27	22	29	29	26	23
Тоос PM2.5	Дундаж	-	0.018	-	0.033	-	-	-	-	0.035	0.040	0.032	0.031
	Хамгийн их	-	0.033	-	0.078	-	-	-	-	0.098	0.068	0.049	0.047
	ХХХ*-с давсан хувь	-	-	-	13	-	-	-	-	17	31	-	-
	Хэмжилтийн тоо	-	31	-	31	-	-	-	-	29	29	26	23
Озон O <sub>3</sub> **	Дундаж	0.047	-	-	0.032	0.027	-	-	0.063	0.035	0.068	0.057	0.066
	Хамгийн их	0.077	-	-	0.051	0.077	-	-	0.095	0.069	0.1	0.103	0.095
	ХХХ*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	51	-	-	93	92	-	-	92	92	90	87	73

\*- Хүлцэх хэм хэмжээ, \*\*- CO, O<sub>3</sub>-ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон

Туул голын усны найрлага Туул-Зайсан харуул цэгийн орчимд бохирдуулагч бодисын хэмжээ хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд хүчилтөрөгчийн хэмжээ горим алдагдаж онцгой их бохирдолтой, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 22.2 дахин, амоны азот 27.0 дахин, нитридийн нэгдэл 7.7 дахин, эрдэс фосфор 5.3 дахин хүлцэх хэм хэмжээнээс хэтэрч Туул голын ус маш бохирдолтой хэвээр байна.

Хүснэгт 29. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м<sup>3</sup>, 5-р сард

	Стандарт хэмжээ	“Туул-Зайсан” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
		Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч (O <sub>2</sub> )	≥6	9.89	хэвийн	2.27	онцгой их бохирдолтой
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ <sub>5</sub> )	≤ 3	1.1		66.7	22.2 дахин
Нитридийн нэгдэл (NO <sub>2</sub> )	≤ 0.02	0.002		0.153	7.7 дахин
Амоны азот (NH <sub>4</sub> )	≤0.5	0.06		13.48	27.0 дахин
Эрдэс фосфор (P)	≤0.1	0.017		0.525	5.3 дахин

\*- Эх үүсвэр: Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори

**Байгаль орчны зөрчил** Нийслэлд 2015 оны эхний 5 сард байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 364 зөрчлийг илрүүлжээ. Илрүүлсэн нийт зөрчлийн 34.1 хувийг агаар, химийн хорт бодисын зөрчил, 28.6 хувийг геодези зурагзүй, кадастрын зөрчил, 22.0 хувийг газрын зөрчил, 4.4 хувийг ойн зөрчил, 2.7 хувийг ангийн зөрчил, 2.2 хувийг газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчил, 1.9 хувийг ургамал, хөрсний бохирдлын зөрчил, 4.1 хувийг бусад зөрчлүүд эзэлж байна.

Илрүүлсэн нийт зөрчилд 40.4 сая төгрөгийн торгууль ногдуулж, ангийн зөрчлөөс 30.0 мянган төгрөгийн нөхөн төлбөр, ойн зөрчил гаргасан иргэдээс 14.1 сая төгрөгийн эд зүйлс хураан авчээ.

Хүснэгт 30. Байгаль орчны зөрчил, төрлөөр

Илрүүлсэн зөрчил, төрлөөр	2014 оны эхний 5 сард			2015 оны эхний 5 сард		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /сая.төг/	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /сая.төг/
Ой	23	9	5.4	4	16	5.8
Ан, амьтан	3	2	-	4	10	1.3
Газрын	10	4	-	8	80	18.1
Ус	3	1	3.6	2	1	-
Ургамал, хөрсний бохирдол	1	1	-	3	7	0.4
Агаар, химийн хорт бодис	8	-	-	16	124	1.7
Газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхай	-	-	-	11	8	3.1
Геодези зураг зүй, кадастр	5	2	0.2	4	104	8.7
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	1	1	4.8	4	10	-
Бусад	11	13	3.5	7	4	1.3
<b>Бүгд</b>	<b>65</b>	<b>33</b>	<b>17.5</b>	<b>63</b>	<b>364</b>	<b>40.4</b>



## ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Нийслэлийн хүн амд 2015 оны эхний 5 сард 14.5 сая м<sup>3</sup>, аж ахуйн нэгж, байгууллагад 4.9 сая м<sup>3</sup> цэвэр усыг борлуулжээ. Борлуулсан усны нийт хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 1.2 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 31. Ус суваг ашиглалтын үйлчилгээ


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014 он V сар	2015 он V сар	$\frac{2015}{2014}$ %
Шахсан ус	мян.м <sup>3</sup>	23187.9	22374.9	96.5
Борлуулсан ус	мян.м <sup>3</sup>	19140.8	19374.3	101.2
Хүн амд	мян.м <sup>3</sup>	14116.5	14481.9	102.6
ААНБ-д	мян.м <sup>3</sup>	5024.3	4892.4	97.4
Татан зайлуулсан бохир	мян.м <sup>3</sup>	18661.2	18974.0	101.7
Хүн амаас	мян.м <sup>3</sup>	13118.2	13449.7	102.5
ААНБ-аас	мян.м <sup>3</sup>	5543.0	5524.3	99.7
Ус борлуулалтын орлого	сая төг	6809.1	11300.1	166.0
Хүн амаас	сая төг	3973.7	6647.1	167.3
ААНБ-аас	сая төг	2835.4	4653.0	164.1
Сувагжуулалтын орлого	сая төг	3793.4	6842.1	180.4
Хүн амаас	сая төг	1931.9	2991.2	154.8
ААНБ-аас	сая төг	1861.5	3850.9	206.9

Нийт борлуулсан усны 75.2 хувийг хүн амд борлуулсан ус, 24.2 хувийг аж ахуйн нэгж, байгууллагад борлуулсан ус эзэлж байна.


Хүн амд түгээсэн цэвэр усны 96.3 хувь буюу 13.9 сая.м<sup>3</sup> усыг төвлөрсөн шугамаар, 531.8 мян.м<sup>3</sup> усыг ус түгээх байраар, 4.8 мян.м<sup>3</sup> усыг тээврээр түгээсэн байна.

Цэвэрлэх байгууламжаар 23.0 сая.м<sup>3</sup> бохирыг цэвэрлэж, аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн 19.0 сая.м<sup>3</sup> бохир шингэнийг татан зайлуулсан байна.

Зураг 30. Борлуулсан ус, сараар, мян.м<sup>3</sup>



Зураг 31. Татан зайлуулсан бохир, сараар, мян.м<sup>3</sup>







### ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2015 оны эхний 5 сард нийт 170 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар буурсан байна. Нийт гамшиг ослын 168 нь хүний үйл ажиллагаатай холбоотой осол, харин 2 тохиолдол нь хүчтэй салхи шуурга болон гахайн үржил-амьсгалын замын хам шинж өвчин байв. Хүний үйл ажиллагаатай холбоотой сум галт хэрэгслийн осол 1, химийн бодисын осол 10, бичил уурхай, нурангины осол 2, усны осол 3, үйлдвэрийн осол 1, бусад осол 151 гарсан байна. Ослоос 112 хүнийг аварч, ослын уршгийг арилгах ажилд нийт 1.8 сая төгрөг зарцуулжээ.

Хүснэгт 32. Гал түймрийн тоо, дүүргээр

Дүүрэг	2014 он	2015 он	$\frac{2015}{2014} \%$
Бүгд	1338	1651	123.4
Багануур	15	29	193.3
Багахангай	2	5	250.0
Баянгол	198	204	103.0
Баянзүрх	318	417	131.1
Налайх	53	42	79.2
Сонгинохайрхан	255	361	141.6
Сүхбаатар	202	231	114.4
Хан-уул	139	145	104.3
Чингэлтэй	156	217	139.1


Нийслэл хотод 2015 оны эхний 5 сард ой хээрийн 9 түймэр, ахуйн 1651 гал түймэр гарчээ. Ахуйн гал түймэр өмнөх оны мөн үеэс 23.4 хувиар нэмэгдсэн байна.

Гал түймрийн улмаас 14 хүн (үүнээс, хүүхэд 3) амь насаа алдаж, 10 хүн (үүнээс, хүүхэд 2) түлэгдэж гэмтжээ. Гал түймрийн аюулаас 317 хүн, 568 байшин барилга, 4.0 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг аварчээ.


Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилбал цахилгаанаас 290, санамсаргүй байдлаас 1203, шалтгаан тогтоогдоогүй 136, бусад шалтгаанаар 22 гал түймэр гарсан байна.

Гал түймэрт 512 гэр, орон сууц, 47 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 72 машин техник, бусад төрлийн 1020 объект өртсөн байна. Гал түймэрт иргэний хувийн өмчийн 1046, төрийн өмчийн 514, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 90, гадаадын хөрөнгө оруулалттай 1 объект өртөж, нийт 10.4 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Зураг 32. Гал түймэр, шалтгаанаар



Зураг 33. Гал түймэр, байршлаар



Нийслэлийн Онцгой байдлын газраас 2015 оны эхний 5 сард 108 барилгын зураг төсөл, ашиглалтанд хүлээн авч буй 228 барилгад хяналт тавьж ажиллажээ. Мөн 7697 айл өрх, 4669 объектод үзлэг шалгалт хийж, 21759 галын зөрчил илрүүлж, 117 байгууллагын үйл ажиллагааг нь зогсоож, байгууллага, албан тушаалтан, иргэнд 1301 заавал биелүүлэх албан шаардлага, 1404 мэдэгдэл хүргүүлж, 30.2 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.



**ГЭМТ ХЭРЭГ**

2015 оны эхний 5 сард 8242 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 15.3 хувь буюу 1096 хэргээр өсчээ.

Гэмт хэргийн илрүүлэлт 54.8 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.0 пунктээр дээгүүр байна.

Зураг 34. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Гэмт хэргийн улмаас 2851 хүн гэмтэж осолдож, 205 хүн нас барж, төр ард иргэдэд 46.8 тэрбум төгрөгийн хохирол учруулсны 20.9 хувь буюу 9.8 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 33.3 хувийг хулгайн, 24.0 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 9.3 хувийг залилан, 7.0 хувийг танхайн, 6.1 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг тус тус эзэлж байна.

Хүснэгт 33. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, төрлөөр, эхний 5 сард

	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2014 он	2015 он	Тоо	Хувь
Хүний амь	47	49	2	4.3
Хүчин	67	53	- 14	- 20.9
Дээрэм	286	213	- 73	- 25.5
Хулгай	2154	2748	594	27.6
Булаалт	87	97	10	11.5
Залилан	560	768	208	37.1
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	1986	1982	- 4	- 0.2
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	405	502	97	24.0
Бусдыг амиа хорлоход хүргэх	154	123	- 31	- 20.1
Ашиглах	79	77	- 2	- 2.5
Танхайрах	585	576	- 9	- 1.5
Бусад	736	1054	318	43.2
<b>БҮГД</b>	<b>7146</b>	<b>8242</b>	<b>1096</b>	<b>15.3</b>

“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2015 оны 5-р сарын танилцуулга

Хүснэгт 34. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, дүүргээр, эхний 5 сард

дүүрэг	Нийт бүртгэсэн гэмт хэрэг		Гэмт хэргийн өсөлт, бууралт	
	2014 он	2015 он	Тоо	Хувь
Багануур	106	130	24	22.6
Багахангай	9	9	-	-
Баянгол	1156	1277	121	10.5
Баянзүрх	1698	2057	359	21.1
Налайх	148	194	46	31.1
Сонгинохайрхан	1292	1407	115	8.9
Сүхбаатар	1098	1474	376	34.2
Чингэлтэй	1008	1091	83	8.2
Хан-Уул	631	603	- 28	- 4.4
<b>ДҮН</b>	<b>7146</b>	<b>8242</b>	<b>1096</b>	<b>15.3</b>

Хүснэгт 35. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо, дүүргээр, 2015 оны эхний 5 сард


дүүрэг	Сэжигтэн тодорхойгүй хэргийн тоо	Үүнээс сэжигтнийг илрүүлж ял сонгосон	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
Багануур	34	22	64.7
Багахангай	1	0	0.0
Баянгол	497	332	66.8
Баянзүрх	1302	656	50.4
Налайх	51	35	68.6
Сонгинохайрхан	857	439	51.2
Сүхбаатар	945	489	51.7
Чингэлтэй	709	397	56.0
Хан-Уул	259	182	70.3
<b>ДҮН</b>	<b>4655</b>	<b>2552</b>	<b>54.8</b>

Хүснэгт 36. Бүртгэсэн хулгайн гэмт хэрэг, дүүргээр, эхний 5 сард

дүүрэг	Нийт хулгайн гэмт хэргийн тоо		Үүнээс: хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо	
	2014 он	2015 он	2014 он	2015 он
Багануур	17	28	14	23
Багахангай	2	2	1	1
Баянгол	315	294	252	238
Баянзүрх	599	760	526	648
Налайх	22	45	16	35
Сонгинохайрхан	411	547	375	497
Сүхбаатар	338	568	248	391
Чингэлтэй	283	352	257	292
Хан-Уул	167	152	144	143
<b>ДҮН</b>	<b>2154</b>	<b>2748</b>	<b>1833</b>	<b>2268</b>

2015 оны эхний 5 сард онц хүнд хэрэг 137, хүнд хэрэг 504 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7.4-12.3 хувиар буурч, харин хүндэвтэр хэрэг 3643, хөнгөн хэрэг 3958 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 15.2-21.3 хувиар өсчээ.

Зураг 35. Гэмт хэргийн тоо, ангиллаар



Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 6001 болж, 2014 оны мөн үеэс 13.3 хувь буюу 703 хүнээр өссөн байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 12.2 хувь буюу 735 нь гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн, 15.6 хувь буюу 935 нь согтуугаар үйлдсэн, 4.8 хувь буюу 290 нь урьд ямар нэг ял шийтгэл хүлээж байсан хүмүүс үйлджээ. Сэжигтэн, яллагдагчийн 4.3 хувь буюу 258 нь хүүхэд, 17.7 хувь буюу 1060 нь эмэгтэйчүүд байна.

2015 оны эхний 5 сард 24179 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 17.8 хувь буюу 5237 хүнээр буурсан байна.